



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20<sup>25</sup> оны 03 сарын 31 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 59.4, 60-р зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн, 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн “Хөх ган” ХК-ийн Төлөөлөн удирдах Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөх ган” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 14:00 цагт Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, “Нэхээсгүй Эдлэл” ХК-ийн байранд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
  - 2.1 Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар хэлэлцэх
  - 2.2 Компанийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
  - 2.3 ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
  - 2.4 Компанийн ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргын цалин, ТУЗ-ийн зардлын төсвийг батлах тухай
  - 2.5 ТУЗ-өөс гаргасан Ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг “Хурал хуралдуудах тухай зар”-ыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 19 дэхь өдөр буюу 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг Хавсралт №1-ийн дагуу баталж, нийтэд мэдээлэх өдрийг ТУЗ-ийн шийдвэр гарснаас хойш 5 дахь өдөр буюу 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар болон өдөр тутмын сонингоор мэдээлэх, хурлын зар мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 2025 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын дэгийг Хавсралт №2-оор баталсугай.
6. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалтыг Хавсралт №3-аар баталсугай. Хавсралт №3-т заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 9:00-17:00 цагийн хооронд “БиДиСек ҮЦК” ХК-ийн төв офис болон компанийн өөрийн байран дээр ирж танилцах боломжтой.
7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг Хавсралт №4-ийн дагуу баталсугай.
8. Үнэт цаасны компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг хурал хуралдах өдөр буюу 2025 оны 05 дугаар сарын 13-ны 14:00 цаг хүртэл байхаар тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг удирдах хурлын даргаар Л.Бямбадорж, хурал зохион байгуулах комиссын даргаар Т.Болор-Отгон, гишүүнээр П.Мөнхтуяа, тооллогын комиссын даргаар Ч.Хос-Од, гишүүнээр Г.Номин-Эрдэнэ нарыг тус тус томилсугай.
10. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гаргасан шийдвэрүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд танилцуулсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах ажлыг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэхийг гүйцэтгэх захирал Л.Бямбадорж-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА *Т. Болор-Отгон* /Б. МӨНХТӨР/

